

**СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2023.06.16

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая төгрөг /	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин /эхний хагас жил/	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
НЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Үндсэн чиг үүрэг-1: Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, санхүүгийн үндсийг бүрдүүлэх							
Зорилт 1. Санхүү, эдийн засгийн нээлттэй, ил тод байдлыг хангах шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах							
1	Байгууллагын 2023 оны төсвийн төслийг батлуулах, 2023-2024 оны дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг боловсруулан, холбогдох байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлнэ.	-	Хуулийн хугацаанд саналыг хүргүүлсэн эсэх	Хуулийн хугацаанд хүргүүлсэн	Хуулийн хугацаанд хүргүүлнэ	Сумын ИТХ-ын 2022.12.20-ны 06 тогтоолоор Сумын Засаг даргын Тамгын газар 2023 онд 812,504,6 мянган төгрөгийн, баг 180,119,7 мянган төгрөгийн төсөвтэй батлагдсан. Эхний хагас жилийн байдлаар сумын Засаг даргын Тамгын газар 320.479,200 мянга, баг 92.924.500 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. 2023-2024 оны дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг боловсруулж байна.	90
2	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах, орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах	-	Хяналт шалгалтын тоо Илрүүлсэн зөрчлийн бууралтын хувь Орлогын биелэлт	- 0 112	1 100 70	2023 оны 5-р сарын 31-ны байдлаар орон нутгийн орлогын төлөвлөгөө 2353,2 сая төгрөг, гүйцэтгэл 2240,8 сая төгрөг буюу 95,2 хувьтай, орон нутгийн авлага 6860,0 мянган төгрөг, өглөг 74772.8 мянган төгрөг байна. Сумын Засаг даргын Тамгын газар болон сумын харьяа байгууллага сургууль, цэцэрлэгийн санхүүгийн хяналт шалгалтын дүгнэлтэд дү шинжилгээ хийж илэрсэн зөрчил, актын түүвэрлэн авч дотоод хяналтыг явуулж хугацаатай үүрэг чиглэл өгч ажилласан.	70

1	2	3	4	5	6	7	8
3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган сайтын хөтлөлтийг тогтмолжуулж санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллана.	-	Хуулийн хэрэгжилтийн хувь	97.5 хувь	100 хувь	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хөгжил сангийн нийт 51 мэдээлэл оруулахаас 49, Сумын ЗДТГ-ын нийт 55 мэдээлэл оруулахаас 54 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.	90
4	Худалдан авах ажиллагааг хулийн дагуу төлөвлөж, тендер шалгаруулалтыг цахимаар зарлаж, хэрэгжилтийг зохион байгуулан, тайлагнана.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Цахимаар зарласан тендер шалгаруулалтын хувь	100 100	100 100	2023 онд ОНХС-ын хөр-рөнгөөр санхүүжүүлэх шилжих хөрөнгө оруулалт, шинээр эхлэх хөрөнгө оруулалт, их засвар, бараа тоног төхөөрөмж худалдан авах нийт 14 ажлыг гүйцэтгэхээр сумын ИТХ-ын хурлаар баталсан. Батлагдсан тогтоолын хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулж цахим тендер шалгаруулалтын ажил хийгдэж байна.	100
Зорилт 2. Төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх, үр ашиггүй зардлыг багасгах							
5	Төсвийн байгууллагууд, Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ, сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх, эрсдэлийг үнэлэх, зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулах	-	Төлөвлөгөөт хяналт шалгалтын тоо Шалгалтад хамрагдах байгууллагын тоо Эрсдлийн үнэлгээ Зөвлөмжийн биелэлтийн хувь	-	1 9 Бага 80	Сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын багаас төлөвлөгөөний дагуу төсвийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд явцын дотоод хяналт шалгалтыг 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.	-
6	Сумын орон нутгийн төсвийн төслийг боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барих, сумын 2024 оны төсвийг батлуулах		Хуулийн хугацаанд аймгийн 2024 оны төсөв батлагдсан байна.	Сумын төсөв 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан.	-	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас баталсан 434,0 сая төгрөг аймагт төвлөрүүлэн гүйцэтгэл 100 хувьтай байна.	100
7	Төсвийн байгууллагууд болон Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч, эд хариуцагч нарт холбогдох журам, заавар, аргачлалыг таниулан сурталчлах, зөвлөгөө мэдээллээр хангах, сургалт		Зохион байгуулсан сургалтын тоо Хамрагдсан байгууллагын тоо Хамрагсан албан хаагчдын тоо	- - -	1 9 18	Санхүү албанаас төсвийн байгууллагын нягтлан бодогч, няравуудад зориулсан сургалтын төлөвлөгөө гаргаж батлуулсан.	30

	сурталчилгаа зохион байгуулах						
8	Шаардлагатай тохиолдолд сумын 2023 оны төсвийн тодотголын төслийг боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барих, 2023 төсвийн тодотголыг батлуулах		Тухайн хугацаанд сумын 2023 оны тодотгосон төсөв батлагдсан байна	2022 онд 1 удаа төсвийн тодотгол хийсэн	Сумын төсвийн тодотголыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	2023 оны 02 дугаар сарын 16-нд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсөвд нэмэлт өөрчлөлт оруулах санал хэлэлцсэн боловч сайжруулалт хийхээр буцаагдсан. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцсэн. 7-р сард хуралдаан зарлагдсан.	70
9	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланг гаргаж аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс, төрийн аудитын газарт хүргүүлэх		“Зөрчилгүй” дүгнэгдсэн байна.	“Зөрчилгүй”	“Зөрчилгүй” дүгнэгдсэн байна.		100
10	Төсвийн байгууллагуудын сүүлийн 3 жилийн /2020,2021,2022/ санхүүгийн аудитын дүгнэлт, зөвлөмж, албан шаардлагад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулах	-	ХШҮ хийсэн байгууллагын тоо Зөвлөмж хэрэгжилтийн хувь Санхүүгийн зөрчлийн бууралтын хувь	-	9 70 70	Санхүүгийн дотоод хяналтын хүрээнд төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар илэрсэн зөрчлийг түүвэрлэж, сургууль, цэцэрлэгт хугацаантай үүрэг даалгавар өгч, зөрчлийг бүрэн арилгах давтан гаргахгүй байх чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. 9-р сард дотоод хяналт шалгалтыг байгууллага бүр дээр хийх ба зөвлөмжийг биелэлтийг шалгаж ажиллана.	70
Үндсэн чиг үүрэг-2: Орон нутгийн чиг үүрэг, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах							
ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
Хүний хөгжлийн бодлогыг дэмжиж, шинжлэх ухаан, инновацид тулгуурлан эрүүл мэнд, боловсрол, соёл, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх							
Зорилт 3. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ							

11	Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны иргэдийг хамруулах.	-	Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь	75.6	50	<p>Халдварт бус өвчний эрт илрүүлгийн дундаж эхний 4 сард 34.5 хувьтай байна.</p> <ul style="list-style-type: none"> Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт 18-с дээш насны 7896 иргэн хамрагдахаас 2497 иргэн хамрагдаж 31.2 хувьтай, Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-с дээш насны 4729 иргэн хамрагдахаас 2267 иргэн хамрагдаж 47.9 хувьтай, Хөхний хорт хавдрын эрт илүүлэг үзлэг шинжилгээнд 30-60 насны 2535 эмэгтэйчүүд хамрагдахаас 1213 эмэгтэй хамрагдаж 47.8 хувьтай, Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 883 эмэгтэй хамрагдахаас 98 эмэгтэй хамрагдаж 11.1 хувьтай <p>Мөн лаборатори нь нэмэлтээр түргэвчилсэн шинжилгээгээр өтгөнд ходоодны шарх шархлаа, бүдүүн нарийн гэдэсний шарх шархлаа, элэгний хавдар, түрүү булчирхайн хавдар гэх мэт 4 төрлийн шинжилгээг иргэдэд хийн үйлчилж байна.</p>	70
12	Хөдөөгийн багийн иргэдэд жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн чиглэлээр хөдөлгөөнт үйлчилгээ үзүүлнэ.	-	Зохион байгуулах арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	2 341	1 250	<p>Өрхийн эрүүл мэндийн төвөөс хөдөөгийн 4,5,6-р багт 3 удаагийн явуулын амбулаторийн үйлчилгээ, томуугүйн вакцин болон явуулын эхо, зүрхний бичлэг, эмийн сангийн үйлчилгээ, товлолын дархлаажуулалтад 209 өрхийн 731 иргэн, бага насны хүүхдийг хамруулсан. Эхний хагас жилийн байдлаар нийт өрхийн 38,3 хувийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулж өмнө оны мөн үеэс 7,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Энхбилэг хувийн эмнэлгээс 5-р сард хөдөөгийн багуудын өдөрлөгт оролцож 275 иргэнд үнэ төлбөргүй үзлэг хийж, хеликобактерийн шинжилгээг төгрөгийн эмийн худалдаагаар үйлчилсэн байна.</p>	100
13	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын идэвхитэй илрүүлэг үзлэгт	-	Зорилтот бүлгийн иргэдийн хамрагдалтын хувь	50,0	30,0	<p>Сүрьеэ өвчний илрүүлэгт хамруулахаар 2028 иргэдийн судалгааг гаргасан, зорилтод бүлгийн 45 жирэмсэн эмэгтэйчүүдийг шинжилгээнд хамруулсан. Эхний 5 сарын байдлаар нийт 8</p>	90

	зорилтот бүлгийн иргэдийг хамруулах.					сүрьеэгийн тохиолдол илэрсэн өрхийн эмнэлэгийн хяналтад эм уулгаж эмчилгээ хийж байна. Мөн 172 жирэмсэн эмэгтэйг тэмбүүгийн түргэвчилсэн шинжилгээнд хамруулж, 12 сорил эерэг гарсан эмэгтэйчүүдийг Нэгдсэн эмнэлгийн халдварт өвчин судлалын тасагтай хамтран эмчлэн эрүүлжүүлж ажилласан.	
14	Иргэдийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх		Үзлэгт хамрагдалтын хувь	100	50	Хүн амын эрүүл мэндийн хяналтыг сайжруулах зорилгоор сумын 18176 иргэнийг 5 бүлгээр ангилан судалгааг гаргасан. Үүнд: 1-р бүлгийн 5679, 2-р бүлгийн 5786, 3-р бүлгийн 1536, 4-р бүлгийн 144, 5-р бүлгийн 31. Бүлгийн судалгаанд тулгуурлан 5000 иргэн эмчийн нарын хяналтад байж эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тогтмол хамрагдсанаар эхний хагас жилийн байдлаар 257 иргэний бүлэг дээшилсэн байна. Өрхийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт эхний хагас жилийн байдлаар нийт 9574 иргэн буюу нийт хүн амын 52,6 хувь хамрагдаж өмнө оны мөн үеэс 8,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хүрсэн түвшин: Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь 52,6 Нийт хүн амын эзлэх хувь – 2,6 хувиар өссөн.	100
15	Сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаанд ХШҮ хийж, арга зүйгээр хангах, захирал эрхлэгч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр дүгнэж үнэлэх	-	ХШҮ хийсэн байгууллагын тоо Зөвлөмжийн тоо Гүйцэтгэлийн хувь	2 2 85	7 3 удаа	Сумын хэмжээнд үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу эхний хагас жилийн байдлаар 3 сургууль, 4 цэцэрлэгийн үйл ажиллагааны сургалтын чанар, үдийн хоолны чанарт нийт 2 удаагийн хяналт шалгалт хийж зөвлөн тусалж, арга зүйгээр хангаж ажилласан. Захирал эрхлэгч нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн гүйцэтгэлд үнэлгээ хийгдэж байна.	90
Биеийн тамир, спорт							
Зорилт 4. Нийтийн биеийн тамир, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлж, тамирчдын өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ							
16	Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх ёс, зан үйлийг хэвшүүлэхэд нийтийн биеийн тамирыг чиглүүлнэ.	-	Чийрэгжүүлэх өрөөний тоо Үйлчлүүлсэн иргэдийн тоо	1 114	1 80	Өрхийн эрүүл мэндийн төвд чийрэгжүүлэлтийн тусдаа өрөө одоогоор байхгүй. Уламжлалтын тусламж үйлчилгээний тасагт үйлчилгээ үзүүлж нийт 259 хүнд чийрэгжүүлэх үйлчилгээг үзүүлсэн байна.	100

17	Сумын 30-64 насны нийт иргэдийг хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамруулах	-	Сорилд хамрагдагчдаас А, В үнэлгээтэй иргэдийн эзлэх хувь	25 хувь	15 хувь	30-64 насны иргэдийг бие бялдрын сорилд хамруулах ажлын хүрээнд хамруулахаар төлөвлөсөн нийт 1300 иргэнээс 200 иргэнийг буюу 15,3 хувийг бие бялдрын сорилд хамруулсан. Хамрагдсан 200 иргэнээс 180 иргэн А, В үнэлгээг авсан байна.	100
18	Биеийн тамир спортын уралдаан тэмцээн, үйл ажиллагаанд иргэдийг оролцуулах боломжийг бүрдүүлэх, нийтийн биеийн тамир, спортоор тогтомол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх .	ОНХС 2.5 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо Нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэсэн иргэдийн хувь	5 601 31%	2 200 15%	Эхний хагас жилийн байдлаар сумын хэмжээнд нийтийг хамарсан биеийн тамир, спортын уралдаан тэмцээнийг 3 удаа зохион байгуулж 756 иргэн буюу эхний хагас жилийн байдлаар нийт хүн амын 8,9 хувийг хамруулсан. Үүнд: 30-64 насны иргэдийг бие бялдрын сорилд хамруулах ажлын хүрээнд 200 иргэнийг бие бялдрын сорилд хамруулсан бөгөөд 180 иргэн А, В үнэлгээг авсан. Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сургуулийн сурагчдын дунд 2 насны ангиллаар 3×3 сагсан бөмбөгийн тэмцээнийг сумын “Хүүхдийн зөвлөл”-өөс зохион байгуулж 43 багийн 176 тамирчин хамруулан 1,000,000 төгрөг зарцуулсан. Мөн төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор төрийн албан хаагчдын дунд “Бид чадна” нөхөрсөг биеийн тамирын арга хэмжээг 11 байгууллагын 200 төрийн албан хаагчийг хамруулан 8 төрлөөр зохион байгуулан 2,970,000 төгрөг зарцуулсан.	100
19	Сумын спартакиадыг 2 жилд 1 удаа зохион байгуулж, иргэд олон нийтийг идэвхтэй оролцуулна.	ОНХС 2.5 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан иргэдийн тоо	0	- -	Засгийн газрын 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлж Аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд төрийн байгууллагуудын хоорондын аялдаа холбоог хангах зорилгоор төрийн албан хаагчдын дунд “Бид чадна” нөхөрсөг биеийн тамирын арга хэмжээг 2023 оны 03 дугаар сарын 25-ний өдөр зохион байгуулж нийт 11 төрийн байгууллагын 200 албан хаагч биеийн тамирын 8 төрлийн тэмцээнд оролцуулан зохион байгуулж сумын ОНХСангаас 2,970,000 төгрөгийг зарцуулсан.	100

Боловсрол

Зорилт 5. Боловсролын үйлчилгээнд тэгш хамруулж, чанар хүртээмжийг сайжруулна

20	Төрийн албан хаагчийн монгол бичгийн мэдлэг чадварыг ахиулна.	ОНХС 1,0 сая	Анхан шатны түвшний мэдлэгтэй ТАХ-ийн эзлэх хувь	50.5	60	Монгол улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 46 дугаар “Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хэрэгжилтийг хангах, 2025 оноос төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлын хүрээнд төрийн албан хаагчийг монгол бичгийн шаталсан сургалтад хамруулах зорилгоор сумын Тамгын газрын албан хаагчдыг төдийгүй сургууль цэцэрлэгийн багш ажилчдыг шаталсан хэлбэрээр сургах ажлыг эхлүүлэн ажиллаж байгаа юм. 9-р сард ахисан шатны сургалтыг явуулахаар төлөвлөөд байна.	70
21	Боловсролыг дэмжих арга хэмжээ зохион байгуулна.	ОНХС 7,0 сая.тө г	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Гүйцэтгэлийн хувь	2 80	1 90	Боловсролыг дэмжих арга хэмжээний хүрээнд Аугаа монгол төрийн бус байгууллагай хамтран “Би монгол хүн” боржигин өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 30 хүүхдийг 6 сард хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.	30
22	Хүүхэд харах үйлчилгээнд хяналт шалгалт хийж, зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулах, стандартыг мөрдүүлэх	-	Хяналт шалгалтын тоо Зөвлөмжийн хэрэгжилт	1 90	1 100	Сүмбэр сумын 3 дугаар багт Билгүүн хүүхэд харах үйлчилгээг иргэн Г.Насантогтох явуулж байгаа бөгөөд хяналт шалгалтыг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн байцаагчтай хамтран явуулж арга зүйгээр хангаж хүүхэд харах үйлчилгээний стандартыг хангуулсан. Хүүхэд харах байрны хэмжээг харгалзан 5 хүүхэд хүлээн авч үйл ажиллагаа явуулж байна.	100
23	Хүүхдийн сэтгэн бодох чадвар, ой тогтоолтыг хөгжүүлэх сургалтын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.	-	Сургалтын төрөл Хамрагдсан хүүхдийн тоо Сургалтын чанарын хувь	5 120 100	6 70 80	Хүүхдийн сэтгэн бодох ой тогтоолтыг сайжруулах зорилгоор “Монголын ухааны академи”-ийг говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд байгуулан ажиллаж байна. Нийт 6 төрлийн хөтөлбөртэй бөгөөд ой тогтоолт, хуруундай гэсэн үндсэн хөтөлбөртэй. Үндсэн хөтөлбөр нь урт хугацааны буюу 2 жилийн хөтөлбөр байх бөгөөд 2 сарын хугацаатай түвшин ахиж суралцана. Богино хугацааны хөтөлбөр нь 7-14 хоногийн хугацаатай 4 төрлөөр хичээллэж байна. 1 дүгээр улиралд	100

						сургалтад хамрагдахаар 60 хүүхэд бүртгүүлсэн бөгөөд анги дүүргэлт 12-16 сурагч байна.	
24	СӨБ, бага, суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	-	Аймгийн дунджаас ахисан хувь	СӨБ 98 Бага 100 Суурь 100 ХБХ хамрагдалт 45	-	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт тойргийг шинэчлэн тогтоосон. 2022-2023 оны хичээлийн жилд 90, бага боловсролын хамран сургалт 100%, суурь боловсролын хамран сургалт 100% байна. Сургуулийн насны хүүхдийн сургууль завсардалтгүй ажиллаж байна.	100
Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал							
Зорилт-6: Хүн амын хөгжлийг дэмжин, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулна.							
25	“Нэг өрх – нэг ажлын байр” арга хэмжээг боловсруулан батлуулах, орлого багатай өрхийн ажил эрхлээгүй байгаа насанд хүрсэн гишүүдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтанд хамруулж, хөдөлмөр эрхэлтийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.	ОНХС	Мэргэжил эзэмшүүлэх сургалтад хамрагдсан иргэдийн тоо Хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамрагдсан иргэний тоо- Орлого нэмэгдсэн өрхийн тоо- Ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо	1 2 22 22	2 2 10 10	Сумын хэмжээнд “Нэг өрх, нэг ажлын байр” хөтөлбөрийн хүрээнд 60 айл өрхийг сонгон аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газартай хамтран ажлын байраар хангах ажлын хүрээнд албан байгууллага бүрд хуваарилах ажилд зуучилж 45 иргэнийг түр ажлын байраар, 5 иргэнийг байнгын ажлын байраар хангагдсан. Мэргэжил олгох сургалтад 10 иргэнийг хамруулсан.	50
26	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэн, 100 доошгүй иргэдийг байнгын, 250 иргэдийг түр ажлын байраар хангана.	-	Түр ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо Байнгын ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо	168 123	50 100	Сумын хэмжээнд хөдөлмөр эрхэлдэггүй 640 иргэний судалгааг гарган хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт 2023.03.17-ний 01/149 тоот албан бичгээр хүргүүлсэн бөгөөд байнгын ажлын байранд 20, түр ажлын байранд 160 иргэнийг хамруулсан.	70
27	Жендерийн эрх тэгш байдлыг хангах, зорилтот бүлгийн иргэдийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хэрэгжилтийн хувь	2 90	1 70	Хүний эрхийн Үндэсний комиссын Говьсүмбэр аймаг дахь салбарын референт Наранбаатартай хамтран “Жендерийн эрх тэгш байдал” сэдэвт сургалтыг 1 удаа зохион байгуулж 46 иргэнийг хамруулсан.	70

28	Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.	ОНХС 11 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Кейс шийдвэрлэлтийн хувь	9 65.6%	3 70%	Гэр бүлийн хүчирхийллийн 13 тохиолдол бүртгэгдсэнээс нийт 23 хохирогчоос насанд хүрсэн 2, бага насны 20, харж хандах хүнгүй ахмад настан 1 байна. Насанд хүрээгүй 1 хохирогчийг түр хамгаалах байрны үйлчилгээнд, ах дүү хамаатан садны хамгаалалтад 6, нийгмийн халамжийн суурь үйлчилгээ, хүнсний дэмжлэг тусламжид 4, хууль эрх зүйн холбон зуучлах үйлчилгээнд 23 хохирогчид тулгамдсан үйлчилгээг үзүүлэн ажиллалаа. Нийт кейсийн 11 буюу 84.6 хувийг шийдвэрлэсэн бүрэн шийдвэрлэгдсэн. Нөхцөл байдлын үнэлгээ хийгдэж байгаа 2 кейс байна. Аймгийн цагдаагийн хэлтэстэй хамтран эрсдэлт нөхцөлд байдаг 41 өрхийн 137 хүүхдэд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Үүний үр дүнд 8 гэр бүлийн хүчирхийллийн тохилдлыг илрүүлэн кейс үүсгэн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн ажилласан.	100
29	Албан бус сургалтын төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	-	Хамрагдсан сурагчийн тоо Хамтран ажилласан арга хэмжээний тоо	32 2	20 1	Сумын хэмжээнд бичиг үсгийн боловсролгүй 14 иргэдийн судалгааг гаргаж Насан туршийн боловсролын төвд хүргүүлсэн. Эдгээр иргэд нь эрүүл мэндийн шалтгааны улмаас сургалтад хамрагдаж боловсрол эзэмших боломжгүй хүмүүс байна. Насан туршийн боловсролын төвтэй хамтран японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж буй интерпренершипийн боловсрол олгох хөтөлбөрт 20 иргэнийг хамруулан ажиллаж байна.	100
30	Сургууль, цэцэрлэгийн хүүхдийг томуугийн вакцинд бүрэн хамруулна.	-	Вакцинжуулалтад хамрагдалтын хувь	50	-	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг шуурхай авах зорилгоор нөөцийн бэлэн байдлын талаарх мэдээллийн сан бүрдүүлж, тухай бүрд шаардлагатай мэдээ, мэдээллээр баяжуулж, хяналт тавин ажиллаж байна. 2023 оны 5 сарын байдлаар 164 хүнд томуугийн дархлаажуулалт хийгдсэн.	70
31	“Халамжаас-Хөдөлмөрт” зорилтын хүрээнд ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр	ХЭД сан	Ажлын байрны тоо, Тарьсан модны тоо	45 1107,0	20 492,0	Халамжаас Хөдөлмөрт зорилтын хүрээнд аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт “Хоггүй сүмбэр-Ногоон хот” төсөл бичиж нийт ажилгүй 45 иргэний түр ажлын байраар ханган ажиллаж	100

	иргэдийг ногоон ажлын байраар хангах, үр дүнг тайлагнах					байна. Төслийн нийт хөрөнгө оруулалт 16,200,0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгож байгаа болно. Эхний хагас жилийн байдлаар 30 иргэнийг түр ажлын байр сумын ногоон байгууламжийн талбайд ажиллуулсан.	
Соёл, урлаг							
Зорилт 7. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёл урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ							
32	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын чуулганыг зохион байгуулах		Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан өвлөн уламжлагчдын тоо	1 55	1 120	Сүмбэр сумын соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын 2 дугаар зөвлөгөөнийг зохион байгуулахаар төлөвлөн 2023 оны 05 сарын 31-ний өдөр соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдаар дамжуулан соёлын биет бус өвийг уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, төрөөс соёлын талаар хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг иргэдэд мэдээлэх зорилгоор "Сүмбэр сумын соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын 2 дугаар зөвлөгөөн"-ийг Говьсүмбэр аймгийн Боржигин өв музей, Дуу бүжгийн Боржигин чуулгатай хамтран 150 өвлөн уламжлагчийг хамруулан зохион байгуулсан. Зөвлөгөөнд Боржигон судлаач профессор Б.Баатархүү илтгэл танилцуулсан. Мөн сумын Засаг дарга Т.Бат-Эрдэнэ, Дуу бүжгийн Боржигин чуулгын дарга Ц.Цэнджав, Боржигон өв музейн захирал А.Ундармаа нар сум болон соёлын байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийн талаар мэдээлэл хүргэсэн.	100
33	Удмын сангаа хамгаалах, хүн бүр удмаа мэдэж, угийн бичгийн хөтлөх ажлыг эрчимжүүлнэ.	ОНХС 1 сая	Угийн бичиг хөтлөгч өрхийн тоо	552	200	Насан туршийн боловсролын төв, Боржигин өв музейтэй Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдлын талаар сургалт нөлөөллийн ажлыг ерөнхий боловсролын сургуулийн болон Политехникийн коллежийн 635 суралцагчид, зорилтот өрхийн 20 иргэн, 54 малчин иргэн, нийт 709 иргэдийг хамруулан зохион байгуулсан байна. 2022 онд сумын хэмжээнд угийн бичиг хөтөлдөг 196 өрх байсан ба эхний хагас жилийн байдлаар 316 өрх болсон байна.	90

						Сургалтыг 9 сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна	
Эдийн засгийн бодлого							
Зорилт 8. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгаас хангах хувь хэмжээг нэмэгдүүлэх, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ							
34	Уламжлалт мал аж ахуйд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, нэг малаас авах ашиг шимийн гарцыг нэмэгдүүлэх зорилгоор зохиомол хээлтүүлэг хийх.	-	Зохиомол хээлтүүлэгт хамруулсан эм хонины тоо Зохиомол хээлтүүлэгт хамруулсан үнээний тоо	2	-	Мал аж ахуйн технологит ажлын хүрээнд сумын Засаг дарга, “Зоо бонитор мөнх” МҮТАҮНэгжтэй байгуулсан гэрээний дагуу сумын нийт ямааны 22,6 хувийг хамруулан хэмжилт хийгээд байна Нийт 99 малчин өрхийн 30248 ямаанд хэмжилт хийж бүдүүн ухна 0.695 гр, өсвөр ухна 0,612 гр, эр ямаа 0.638 гр, эм ямаа 0,501, өсвөр 372 гр, сумын дүнгээр ямааны ноолуурын гарцын дундаж 0,564 гр байгаа нь өмнөх оноос 0,075 гр-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	90
35	Хүнсний үйлдвэрлэлд гахай, тахианы аж ахуйгаас бэлтгэх бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлэх.	-	Бэлтгэсэн гахайны махны нэмэгдсэн хэмжээ тн Тахианы махны нэмэгдсэн хэмжээ тн	0,8 0,63	0,5 тн 0,3 тн	Энэ онд 12 өрх, 1 ААНБ 194 гахай, 12 өрх 160 тахиа, галуу 1 өрх 1 цацагт хяруул 369 тэжээвэр амьтан тоологдсон байна. Энэ нь өмнөх оноос гахай 41, тахиа 72 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Одоогийн байдлаар 1,9 тн гахайн мах, тахиан мах 0,2 тн үйлдвэрлэсэн нь өмнөх оны энэ үеэс 0,09 тн махаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үхэр, хонийг махны, ямаа ноолуурын чиглэлээр үржүүлэх, гахай, тахиа үржүүлэгчдийг бодлогоор дэмжих ажлын хүрээнд эрчимжсэн мал аж ахуйн бүсэд газар олгохоор төлөвлөж 11 мал бүхий, 7 гахай тахиатай иргэн очиж суурьшихаар өргөдлөө өгөөд байна.	70
36	Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдлээс хамгаалан, бэлэн байдлыг хангаж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлнэ	ОНХС 2,5 сая	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн хувь	90 хувь	-	Хугацаа болоогүй 8 дугаар сард нөөц бүрдүүлэлт хийнэ. 2022 оны нөөц бүрдүүлэлтээс 2023 оны 02 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд сумын аюулгүй нөөцийн 50 тн өвс, 10 тн тэжээлийг сумын малчин өрхүүдэд тараасан. Нийт 160 өрхөд өвс, давхардсан тоогоор 80 өрхөд тэжээл, мөн аймгийн Засаг даргын санаачлагаар аймгийн аюулгүй нөөцийн 1820 боодол өвсийг хөдөөгийн 4,5,6 дугаар багийн 455 өрхөд олгосон.	80
37	Ариутгал халваргүйжүүлэлт, сэг зэм	ОНХС	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	1	Сүмбэр сумын Найрамдал хотхоны зүүн урд байрлалтай малын өвөлжөө, хаваржаанд 2-р багийн иргэний 130 малыг олон тооны нохой	100

	устгах ажлыг зохион байгуулах.	2,5 сая	Устгасан сэг, зэмийн хэмжээ тн	240	12	барьсан тухай мэдээллийн дагуу Сүмбэр сумын 6 албан хаагч, Мал эмнэлэгийн газрын 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлыг хэсэг ажиллаж хүнд даацын ковш, том хогийн машин, 2 жижиг машинаар 130 малын сэг зэмийг булж устгасан. Хашаа хорооны 264 м2, худаг 50 м2, бэлчээрийн талбай 70 м2, устгалын цэг 60 м2 талбай нийт 444 м2 талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн. Мөн 4 дүгээр багийн нутагт хонины цэцэг өвчин гарсантай холбогдуулан голомтын өрхийн 2 хашаа хороо, орчны нийт 3045м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийгээд байна. Аймгийн Мал эмнэлгийн газар 4, 5, 6-р багийн малчидтай хамтран тус багийн бэлчээр нутагт төвлөрсөн 300 орчим бод, 650 орчим бог нийт 210тн малын сэг зэм хог хаягдлыг цэвэрлэн хогийн цэг дээр төвлөрүүлэн ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.	
38	Малын ашиг шимийн судалгааг тогтоох шинэчлэн	ОНХС 0,5 сая	Ноолуурын дундаж гарц гр Ноосны дундаж гарц микрон	460 1,2	480 -	Мал аж ахуйн технологит ажлын “Зоо бонитор мөнх” МУТАҮНэгжтэй байгуулсан гэрээний дагуу 5 сарын 05-ны өдрийн байдлаар сумын нийт ямааны 16,3 хувийг 75 малчин өрхийн 21740 ямаанд хэмжит хийж бүдүүн ухна 0.693 гр, өсвөр ухна 0,625 гр, эр ямаа 0.644 гр, эм ямаа 0,508, өсвөр 380 гр, сумын дүнгээр ямааны ноолуурын гарцын дундаж 0,570 гр байгаа нь өмнөх оноос 0,75 гр-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна	100
39	Мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг зохион байгуулна.	СОНХ С /50,0/	Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-106.2 мян.тол Гоц халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-1.050 мян.тол Зооноз өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-95.0 мян.тол	106.2 1.050 95.0		Ужиг халдварт өвчнөөс сэргийлэх тарилгад эхний хагас жилд 76,4 мян.тол хамруулахаас 28,0 мян.тол мал хамруулж 36,6 хувьтай. ДХХ энтеробактериозоос сэргийлэх вакцин технологит хугацаандаа нийлүүлэлт хийгдээгүйгээс дархлаажуулалтын ажил хийгдээгүй байна. -Гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх тарилгад 18,6 мян.тол мал, амьтан хамруулахаас 17,3 мян.тол мал, амьтан хамруулж гүйцэтгэл 93% -Зооноз өвчнөөс сэргийлэх арга хэмжээ эхний хагас жилд төлөвлөлт хийгдээгүй.	70

			Шимэгчлэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо-579.1 мян.тол	579.1		-Шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1500 бог, 171 бод малыг хамруулсан байна.	
40	Аймгийн “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” арга хэмжээний төлөвлөгөөнөөс хамааралтай заалтыг хяналтад авч эзэнжүүлж, хэрэгжилтийг хангах		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	80	“Эрүүл хүнс, эрүүл Монгол” арга хэмжээний хүрээнд Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнсний дэлгүүрүүдэд 2023.05.16-2023.05.26-өдрүүдэд Аймгийн Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газартай хамтран бараа бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтад хяналт шалгалт хийж нийт 28 хүнсний дэлгүүрээс хадгалалтын горим алдагдсан хугацаа нь дууссан хурдан муудах / хагас боловсруулсан бүтээгдэхүүн, хоол амтлагч, тараг, майонез /78 ш 344950 төгрөгийн бүтээгдэхүүнийг акт хөтлөн газар дээр нь устгаж харин удаан хугацаагаар хадгалах боломжтой хугацаа нь дууссан /тамхи, ундаа, пиво, төрөл бүрийн печень, чихэр, бэлэн гоймон, лаазалсан бүтээгдэхүүн гэх мэт/ 18 нэр төрлийн 1199 ш 5,1 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг акт хөтлөн орон тооны бус устгалын комисст хүргүүлсэн. 06 сарын 15-25-ний хооронд хоол үйлдвэрлэдэг газруудад хяналт шалгалт хийхээр төлөвлөж байна	70
Зорилт 9. Хоршоо, ахуй үйлчилгээ, эрхлэгчдийг чадавхижуулж, ажлын байрыг нэмэгдүүлэх орон нутгийн брэндийг хөгжүүлэн , бичил үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.							
41	Суманд үйл ажиллагаа явуулж байгаа бүх төрлийн хоршооны үйл ажиллагааг дэмжиж, хоршооны байртай болгох, хоршоодыг чадавхижуулах, уулзалт зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	-	Хамрагдсан хоршооны тоо Гишүүдийн тоо Зохион байгуулсан үзэсгэлэн худалдаа, арга хэмжээний тоо	16 68 7	4 23 2	Сумын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж буй 16 хоршооны дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоод хүргүүлсэн. ХААХХолбоотой хамтран хоршооны гишүүдийг чадавхижуулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх, бусад аймаг сумын хоршоодын үйл ажиллагаатай танилцах туршлага солилцох, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах талаар 4 зорилт 15 заалт бүхий ажлын төлөвлөгөөг батлуулан 4 заалт бүрэн хэрэгжиж, 2 заалт хэрэгжилтийн шатанд явж	70

						байгаа ба бусад заалтын хугацаа болоогүй байна. Хэрэгжилт 40 хувийн биелэлттэй байна. Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан “Хоршоод мах боловсруулах үйлдвэрийн бизнес түншлэл” зөвлөгөөнд 4 хоршооны 6 гишүүн хамрагдсан. Үүний хүрээд мах худалдан борлуулах талаар Дорнод аймгийн 2 хоршоотой хамтран ажиллах гэрээ байгуулсан.	
42	Явуулын ахуйн үйлчилгээг зохион байгуулах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан хөдөөгийн багийн тоо Хамрагдсан иргэдийн тоо	2 3 152	-	6-р сард зохион хөдөөгийн багуудад зохион байгуулагдсан “Хөдөөгийн баясгалан” өдөрлөгийн хүрээнд явуулын ахуй үйлчилгээг 4 төрлөөл малчдад үйлчилж нийт 38 малчин иргэнд хамрагдсан. Нийт үйлчлүүлсэн малчдын 76,3 хувь 28 малчин үс засуулах үйлчилгээ авсан байна.	100
43	Стандартын шаардлага хангасан зоорь, агуулахын тоог нэмэгдүүлж, зоорины стандартын хэрэгжилтийг хангуулна.	-	-Сургалтийн тоо -Зээлийн дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж тоо Мах, төмс хүнсний ногоо бэлтгэж иргэдэд нийлүүлэх тн Ариутгал халдваргүйжүүлэлт тоо	1 0 290 2	1 - - 1	Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийн тэргүүлэх чиглэлийг аймгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулж сумын ИТХурлаас 4 зорилт 8 чиглэлээр баталсан. Сумын тэргүүлэх чиглэлд мах, хүнсний ногооны зоорь, агуулахын чиглэл батлагдаагүй тул зээл дэмжлэг үзүүлээгүй байна. Аймгийн ЖДҮДС-ийн хүрээнд 2023 онд сумын 2 аж ахуй нэгж мах, төмс хүнсний ногооны зоорь барих төсөл эхний шатанд дэмжигдсэн байна.	70
44	Мал нядалгааны цехүүдийг дэмжиж, үйл ажиллагаанд нь стандартыг мөрдүүлнэ.	-	-Зохион байгуулах сургалтын тоо -Сурталчилгаа, мэдээлэл -Зээлийн дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж тоо	2 2 0	1 2 -	Аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 4 мал нядалгааны цехүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж 2 аж ахуй нэгжийн үйл ажиллагааг түр зогсоосон. Мөн хонины цэцэг өвчин гарсантай холбогдуулан 21 ширхэг заавар зөвлөмж өгч ажилласан. Мал эмнэлэг ариун цэврийн 35 шинжилгээний сорьц авсан үүнээс махны 30ш сорьц, сүүний 5ш сорьцыг авч шинжилгээнд хамруулсан.	70
45	Үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж хоршоо хөгжүүлэх сан болон ЖДҮДСангаас хөнгөлттэй зээл олгоно.	ХХС 338,0 сая.тө г	Зээл олгосон үйлдвэрлэлийн тоо	1	-	Аймгийн ЖДҮДСангийн хөнгөлөлттэй зээлэнд хамрагдахаар 7 аж ахуйн нэгж 857,5 сая төгрөгийн төсөл хүргүүлээд байна. 2023 онд хоршоо хөгжүүлэх сангаас 338 сая төгрөгийн зээлийг олгохоор сумын ИТХ-аар батлуулсан. Одоогоор	100

						жилийн эцсийн үлдэгдэл 123,1 сая төгрөг, эргэн төлөлтөөр 81,3 сая төгрөг, нийт 204,4 сая төгрөг төвлөрөөд байна.	
Зорилт 10. Бэлчээрийн менежментийг тогтвортой байдлыг хангах, тариалангийн үйлдвэрлэлийн нөөц ашиглалтыг сайжруулж, төмс, хүнсний ногооны хангамжийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ							
46	Тариалангийн зориулалтаар олгосон газрыг зориулалтын дагуу ашиглуулах талаар арга хэмжээ зохион байгуулна.	-	Тариалангийн зориулалтаар ашигласан талбайн хувь хэмжээ	100 га талбайгаас 41га буюу 41 хувь	50 хувь	Сумын эргэлтийн талбайн хэмжээ 65 га бөгөөд өмнөх онд 37.1 га тариалалт хийсэн бөгөөд энэ онд 39 га талбайд тариалалт хийхээр төлөвлөн 6 сарын байдлаар төмс 10 га, хүнсний ногоо 5,3 га талбайд тариалалт хийн ажиллаж байна. Хөнгөлттэй нөхцөлөөр төмс, хүнсний ногооны үрийг 25 иргэнд олгосон. 2022 онд 100 га талбай мод үржүүлгийн чиглэлээр олгогдсон бөгөөд 2023 онд 50га Сүмбэр сумын 4-р багийн нутаг дэвсгэрт 50 га газарт мод болон ногоон тэжээл тариалахаар 1 иргэнтэй гэрээ байгуулан ажиллахаар төлөвлөж байна	80
47	Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хүлэмжийн аж ахуйн ургацыг нэмэгдүүлсэн хувь хэмжээ	1 29%	-	Аймгийн Хүнс Хөдөө Аж Ахуйн газартай хамтран 2023 оны 05.29-ний өдөр 32 м ² талбайтай хүлэмжийг 33 иргэнд хүлээлгэн өгсөн. Өмнөх оноос 6 хувиар өссөн Одоогоор иргэд хүлэмждээ тариалалтын ажлыг эхлүүлээд байна.	70
48	Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлчээрт шинээр гаргасан худгийг орон нутгийн өмчлөлд бүртгэх, мөн ашиглагдахгүй байгаа худгийг өмчлөлөөс хасуулах ажлыг зохион байгуулах.	-	Шинээр гаргасан худгийн тоо Өмчлөлөөс хасуулсан худгийн тоо	2 -	1 -	Одоогийн байдлаар шинээр гаргасан худаг байхгүй. Худгийн ашиглалтын хугацаанаас хамаараад өмчлөлөөс хасуулсан худаг байхгүй. Өөрийн хөрөнгөөр худаг гаргах хүсэлт ирсэний дагуу тухайн газрын ойр орчмын айл өрх болон бүлгийн малчдын зөвшөөрлийн гарын үсэг тамга тэмдгийг үндэслэн Байгаль орчин аялал жуулчлалын газарлуу сумаас зөвшөөрсөн бичгийг хүргүүлсэн.	100
49	Бэлчээрийн хамгаалах малчдын бүлэг байгуулан, зохистой ашиглах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна.	-	Бүлгийн зохион байгуулалтанд хамрагдсан малчдыг хувь Нөхөн сэргээлт хийгдсэн талбайн хэмжээ	73.1 хувь 15га	80 хувь 16 га	Малчдын бүлгүүдтэй хамтран бэлчээрийг хамгаалах нөхөн сэргэх боломжийг хангах зорилгоор өвөлжөөнийхөө ойр орчмыг бэлчээрийг чөлөөлөх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар бэлчээрийн талбай хэмжээ багатай байгаа тул хашиж хамгаалсан газар байхгүй болно.	50

НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Зорилт 11. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник технологи нэвтрүүлж хүрээлэн буй орчны бохирдол доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ

50	Газар зүйн нэрийг сумдаар тодотгох ажлыг зохион байгуулж мэдээллийн санг цахимжуулна.	-	Мэдээллийн сангийн гүйцэтгэлийн хувь	70	100	Газар зүйн нэрийн хээрийн судалгаа тодруулалт хийх ажлыг орон нутгийн хөгжил сангийн 4.5 сая төгрөгөөр Эс Эм Стар Геод ХХК-тай гэрээ хийж гүйцэтгүүлсэн.	100
51	Туурь, хур хог хаягдал бүхий талбайн хэмжээг үе шаттайгаар цэвэрлэх ажлыг зохион байгуулах.	ОНХС 19 сая төгрөг	Цэвэрлэсэн талбайн хэмжээ га Зарцуулсан хөрөнгө-	4.5 6.0 сая	10 9 сая	Сумын хэмжээнд барилгын туурь, хур хог хаягдал бүхий нийт 268.6 га талбай байдгаас 18 газрын 20 га талбайг цэвэрлэхээр төлөвлөн 19,0 сая төгрөгийг төсөвлөн батлуулсан 3-р улиралд зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа, аймгийн Мал эмнэлгийн газар, малчидтай хамтран 4, 5, 6-р багийн нутаг дэвсгэрт төвлөрсөн 300 орчим бод, 650 орчим бог нийт 210 тонн малын сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэн ариутгал халдваргүйжүүлэлт хийж төвлөрсөн хогийн цэгт булж устгал хийгдсэн. Дээрх арга хэмжээнд ОНХС мал хамгаалах арга хэмжээний зардлаас сая төгрөг зарцуулагдсан.	70
52	Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган, сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.	ОНХС 11,1 сая төгрөг	Хуулийн хэрэгжилт, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100	70	Хоггүй Сүмбэр пэйж хуудсыг ажиллуулан төрийн болон орон нутгийн өмчийн 32 байгууллагууд 14 хоног тутамд нийтийн эзэмшлийн хуваарьт талбайн цэвэрлэгээг зохион байгуулж, хийсэн ажлаа тайлагнаж ажиллаж байна. □□□□"Хүн бүр байгаль хамгаалагч" аянд нэгдэн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 28 байгууллага, 150 гаруй иргэдийг хамруулан 2 цэцэрлэгт хүрээлэнг цэвэрлэж 36 тн хог хаягдал, бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулан 34 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн.	100
53	Хог хаягдлын ангилан ялгах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг бодлогоор дэмжин ажиллаж иргэн аж ахуйн нэгж байгууллагын санал санаачлагыг дэмжих		Зохион байгуулсан арга хэмжээний тоо Дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээ /хувь/ Дэмжлэг үзүүлсэн ААНБ-ын тоо	2 1 1	1 1 -	Суманд энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэхээр "Чойр дахивар эрдэнэ хоршоо" байгуулагдаж, дахивар хог хаягдлыг хагас жилийн байдлаар 2 цэгт худалдан авч, төрийн 6 байгууллагатай гэрээ байгуулан УБ хот руу 3тн хуванцар сав, 5000 шил, мөн иргэн	70

			Санхүүжилтийн хэмжээ /сая.төгрөг/	-	-	Түмэн-Өлзий нь 3тн хуванцар тээвэрлэж борлуулсан байна.	
54	Ундны усны эх үүсвэр болон ус түгээх байрнуудын эрүүл ахуйн бүсэд байрлаж байгаа айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан доторлогоотой бие засах газартай болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.	-	Хамрагдсан өрхийн тоо	8	-	Сумын Усан сан, ус түгээх байрууд нь “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-т ус олборлон түгээх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага болох Ус –Ду ОНӨААТҮГ-н харьяалалд шилжсэн бөгөөд ус түгээх байруудыг төвлөрсөн системд бүрэн холбосон 12 ус түгээх газруудын хамгаалалтын зурвас болон тэрэгтийн ундны усны эх үүсвэрийн эрүүл ахуй хамгаалалтын бүсийг сэргээн засаж 120 мод тарьж ойжуулах арга хэмжээг авсан. Сумын 3-р багийн “Аюулгүй жишиг хороолол”-ийн 4 айл өрх хөрсөнд нэвчдэггүй био нойл хийж ажилласан. Сумын 4-р багийн нутаг орон нутгийн ТХГазар болох Тэрэгтийн ус хангамжийн эх үүсвэрийн орчны бүсэд байрлах 10 айл өрх, 3-р багийн Тохижилтын гүний худгийн орчны бүсэд байрлаж байгаа 11 айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан доторлогоотой бие засах газартай болгох ажлыг 7-р сард зохион байгуулахаар төлөвлөд байна.	90
55	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, ЗГ-ын 2022 оны 02 дугаар тогтоолын дагуу төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.	46,183 сая төг	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр төсөв батлуулах Мэдээллийн сан www.eic.mn -д хугацаанд нь үнэн зөв оруулсан байдал Батлагдсан төсөв, зарцуулалтын дүн	-	Төсөв батлуулсан байна. Тухай бүр 20,0 сая 100	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын 2023 оны Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу 10 арга хэмжээг төлөвлөн, 105,183.0 сая төгрөгийн төсвийг батлуулсан. Мэдээллийн сан EIC.mn цахим сайтад 01-р сарын 25, 07-р сарын 25-ны дотор төлөвлөлт, тайлагналтыг шивж оруулах төлөвлөгөөтэй байдаг ба 2023 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 01 сарын 25-ны дотор шивж оруулсан. Эхний хагас жилд 4 арга хэмжээг хэрэгжүүлэн 41,0 сая төгрөгийг зарцуулан ажиллаад байна.	70

56	Түгээмэл тархацтай ашигт малтмалын гэрээ байгуулж олборлолт явуулсан газарт техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг зохион байгуулах.	ОНХС 4 сая	Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ га Орон нутгийн орлогод төвлөрүүлсэн мөнгөн дүн	5 18.5 сая	-	Хагас жилийн байдлаар түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглуулах гэрээг 11 иргэн, 4 компанитай байгуулж, 8,597,500 төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлээд байна. 09 сарын эхээр олборлолт явуулсан 3 газарт /2.6 га/ техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөөд байна.	70
57	Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээн нутагшуулах, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	ОНХС 1,5 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	1	Сумын 5-р багийн нутаг Улсын Тусгай хамгаалалтай Чойрын Богд ууланд 200 боодол өвс, 5 тн хужрыг 5 цэгт тараан байршуулах ажлыг 4-р улиралд зохион байгуулахаар төлөвлөн 2,683.0 сая төгрөгийг төсөвлөөд байна.	100
58	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулан, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог эрчимжүүлж, арчилгаа, хамгаалалтыг сайжруулна.	ОНХС ан 58,5сая	Зохион байгуулсан арга хэмжээ Шинээр тарьсан модны тоо- Нэмэгдүүлсэн ногоон байгууламжийн хэмжээ /га/ Ургалтын хувь- Хамрагдсан иргэдийн тоо- Хамрагдсан ААНБ-ын тоо- Модны урамшуулалд хамрагдсан иргэдийн тоо-	5 19412 6.7 78.4 522 80 15	1 38400 4 70 250 70	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хаврын тариалалтын арга хэмжээг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 650 албан хаагч, 756 иргэн хамруулсан. Төрийн 31 байгууллагын 650 албан хаагч мод үржүүлгийн газрын хуваарьт талбайд аймгийн хилийн зурвас хэлбэрээр 2600 хайлаас мод, төвийн 3 багийн 569 өрх хашаандаа, 4 нэр төрлийн 1940 ширхэг мод, хувийн хэвшлийн 8 аж ахуй нэгж өөрийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн талбайд 6 нэр төрлийн 3000 мод, засмал зам дагуу 5 нэр төрлийн 568 мод, 2 цэцэрлэгт хүрээлэнд 1600 нийт 8971 мод буцыг шинээр тарьж, ойн зурваст төрийн болон орон нутгийн өмчийн 24 байгууллага 863 мод нөхөн тарилт хийсэн. 2023 онд сумын хэмжээнд нийт 38400 мод шинээр тарихаас хаврын тарилтад 21000 мод бут шинээр тарьсан. Ургалтын явцыг 8-р сард аймгийн БОАЖГ, сум дундын ойн ангитай хамтарсан ажлын хэсэг тоолж, ургалтын хувийг тооцно.	70
59	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ийн үйл ажиллагаа, менежментийг сайжруулж, удирдлага арга зүйгээр хангаж, гүйцэтгэлийн үр дүнг тооцож ажиллана.	-	Гүйцэтгэлийн үр дүн хувиар	81	85	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-ын эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт гарч ирээгүй байна. Санхүүжилт олгохтой холбоотой сар бүр орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах, олгосон санхүүжилтийн тайлан мэдээг улирал бүр авч санхүүгийн хяналт тавин ажиллаж байна.	30

60	Суурьшлийн бүсээс мал, гахай зэрэг амьтдыг гаргах ажлыг зохион байгуулна.	-	Суурьшлийн бүсэд байгаа мал, гахай, тахиаг гаргасан удаа тоогоор Арга хэмжээ тооцсон удаа	4 2	- -	Суурьшлын бүсэд мал маллаж байгаа иргэдийг эрчимжсэн мал аж ахуйн бүс рүү гаргахаар төвд малаа малладаг төвийн 3 багийн 14 айлын мал болон тэжээвэр амьтдын мэдээллийн суурь судалгааг гаргасан. Эдгээр айлуудыг эрчимжсэн мал аж ахуйн бүс рүү гаргах газар олголтын асуудлыг 2-р улирлын сумын ИТХ-аар оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн ногоон байгууламжид орсон малыг суурьшлийн бүсээс гарган 2 айлд хугацаатай албан шаардлага өгч ажилласан.	80
61	“Жорлонгоо өөрчилье” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.	ХХО	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Өөрчилсөн жорлонгийн тоо	1 30	1 -	“Жорлонгоо өөрчилье” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор БОАЖГ-тай хамтран нийт 536 айл өрхөд гарын авлага тараасан. Сумын хэмжээнд хөрсөнд нэвчдэггүй соруулдаг эко 00 3-р багийн 4 өрх, 2-р багийн 2 өрх нийт 6 өрх шинэчилж хийсэн байна. Сумын 4-р багийн нутаг орон нутгийн ТХГазар болох Тэрэгтийн ус хангамжийн эх үүсвэрийн орчны бүсэд байрлах 10 айл өрх, 3-р багийн Тохижилтын гүний худгийн орчны бүсэд байрлаж байгаа 11 айл өрхүүдийг стандартын шаардлага хангасан доторлогоотой бие засах газартай болгох ажлыг 7-р сард зохион байгуулахаар төлөвлөөд байна.	70
Зориль 12. Сумын төвийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлнэ							
62	Шинэ суурьшлын бүсэд цахилгаан татах /шилжих хөрөнгийн ажил/	ОНХС	Гүйцэтгэлийн хувь Зарцуулагдах хөрөнгийн хэмжээ	-	-	2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 2-р багийн Бурхант суурьшлын бүсэд цахилгаан татах ажлыг Нуклон ХХК 141,460,467 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэж 2023 оны 04 сарын 26-ны өдөр улсын комиссын бүрэлдэхүүн байнгын ашиглалтад хүлээн авсан. Тус ажлын хүрээнд 6 кВ болон 0,4 кВ-ын агаарын шугамын ажил хийгдэж нийт 40 айл өрх цахилгаанаар хангагдах боломжтой болсон.	100
63	Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажил /шилжих хөрөнгө/	ОНХС	Гүйцэтгэлийн хувь Шилжих хөрөнгө	-	-	Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын гадна фасад, хойд талын өрөө тасалгааны ажлын засварын ажлыг 2023 оны 06 сарын 12-ны өдрөөс эхлүүлсэн. Гүйцэтгэл 30 хувьтай явагдаж байна.	30

	гадна талбайн тохижилтын ажил гүйцэтгэх						
64	Хог хаягдал зөөвөрлөх авто машин худалдан авах /шилжих хөрөнгө/		Гүйцэтгэлийн хувь Авто машины тоо		100 1	2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Хог хаягдал зөөвөрлөх авто машин”-ыг Буянт суваргын булаг ХХК 98,272,000 мянган төгрөгийн төсөвт өртөгөөр гүйцэтгэж 2023 оны 03 сарын 30-ны Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ-нд комисс хүлээлгэн авч ашиглалтад оруулсан.	100
65	Тагтын эгнээнд худаг гаргах ажил	ОНХС	Шинээр гаргах худгийн тоо Хөрөнгийн хэмжээ -	-	1	2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх сумын 3-р баг “Тагтын эгнээнд худаг гаргах ажил”-ын тендерийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан. Тус тендерт оролцсон компаниуд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар заалтыг хангаагүй тул татгалзаад дахин тендер зарлаад байна.	70
66	Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмж суурилуулах ажил	ОНХС	Гүйцэтгэлийн хувь Хөрөнгийн хэмжээ	-	-	Сумын 3-р баг Гашууны 1-5 дугаар эгнээ, 4-р багийн төвийн -гэрэлтүүлгийн ажлын техникийн тодорхойлолт боловсруулж батлуулсан тендер шалгаруулалтыг цахимаар зарласан.	50
67	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилтыг сайжруулах	ОНХС	Гүйцэтгэлийн хувь Хөрөнгийн хэмжээ	-	-	Хүүхдийн тоглоомын талбайн тохижилтыг сайжруулах ажлын тендерийг 2023 оны 03 сарын 30-ний өдрөөс нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж тус ажилд 1 компани тендерийн баримт бичиг болон үнийн санал ирүүлсэн. Тендерт оролцогч байгууллагууд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 14-16 дугаар заалтуудыг хангаагүй тул тус тендер нь амжилтгүй болж 2023 оны 05 сарын 11-ний өдөр дахин зарласан.	50
68	Ерөнхий боловсролын сургуулиудын камержуулалтын ажил	ОНХС	Гүйцэтгэлийн хувь Хөрөнгийн хэмжээ	-	100 45,0 сая.төг	Ерөнхий боловсролын сургуулиудын камержуулалтын ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж хамгийн сайн үнэлэгдсэн “Сонголт нар” ХХК-тай 38,830,556 мянган төгрөгийн төсөвтэй 2023 оны 04 сарын 20-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ерөнхий боловсролын 1,2 сургуулиудын гадна дотор нийт 67 камерыг суурилуулж гүйцэтгэлийн ажил 100	100

						хувь дуусаж ажил хүлээн авах комиссын бүрэлдэхүүн ажиллаж ашиглалтад оруулсан.	
69	4,5,6-р багуудын халаалтын системийг сайжруулах ажил	ОНХС	Гүйцэтгэлийн хувь Хөрөнгийн хэмжээ	-	100 36,0 сая.төг	Хөдөөгийн 4,5,6-р багийн төвийн халаалтын системийг сайжруулах зорилгоор газрын хийн халаалтын системийн техникийн тодорхойлолт боловсруулж байна.	30
70	Иргэний танхим, төрийн үйлчилгээг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	ОНХС	Бараа нийлүүлэлтийн хувь Хөрөнгийн хэмжээ	-	100 75,0 сая.төг	Иргэний танхим, төрийн үйлчилгээг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажлын нийлүүлэгч сонгон шалгаруулах тендерийг 2023 оны 05 сарын 04-ний өдрөөс нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж тус ажилд 2 компани тендерийн баримт бичиг болон үнийн санал ирүүлсэн. Тендерт оролцогч байгууллагууд нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 14-16 дугаар заалтуудыг хангаагүй тул тус тендер нь амжилтгүй болсон тул тус тендерийг дахин зарласан.	70
71	1-р багийн нийтийн эзэмшлийн орон сууцанд усны чанар сайжруулагч төхөөрөмж худалдан авах	ОНХС	Тоног төхөөрөмжийн тоо Хөрөнгийн хэмжээ	-	1 ш 30.0 сая.төг	1-р багийн нийтийн эзэмшлийн орон сууцанд усны чанар сайжруулагч төхөөрөмж худалдан авах ажлын тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан. Тус тендерт үнийн санал болон тендерийн баримт бичиг ирүүлсэн Ирмүүн бармат ХХК нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 14-16 заалтыг хангаагүй тул тус тендер амжилтгүй болсон учраас төсвийн тодотголд оруулахаар сумын ИТХ-ын зөвлөлд танилцуулагдаад байна.	50
72	Эмнэлгийн ажилчдын барилгын их засварын ажил	ОНХС ан	Гүйцэтгэлийн хувь Зарцуулсан хөрөнгө		-	Тус ажлын хүрээнд нийтийн байрны зориулалтаар 3,2,15-р байрнуудын 4 байранд их засвар хийж 11 өрхийг оруулахаар төлөвлөн зураг төсөв хийгдэж тендер шалгаруулалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Нэршлийг өөрчилж батлуулахаар төслийг сумын ИТХ-д өргөн барьж зөвлөлийн хуралд танилцуулаад байна.	30

73	2 дугаар сургуулийн спорт зааланд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах	ХХО	Бараа нийлүүлэлтийн хувь Хөрөнгийн хэмжээ		100 15,0 сая.төг	2 дугаар сургуулийн спорт зааланд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах ажлыг хүрээнд “Хэв хашмал хуванцар” ХХК-аас 4 хос 49 сандал, “Уухай технологи” ХХК-аас электрон онооны самбар, “Ургамлын далай” ХХК-аас сагсны шилэн самбар, шүүгчийн сандал худалдан авах гэрээг байгуулсан. Тус тоног төхөөрөмжүүдийг ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2023 оны 05 сарын 30-ний өдөр ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд хүлээлгэн өгсөн. Гүйцэтгэгч: Хэв хашмал хуванцар ХХК, Уухай технологи ХХК, Ургамлын далай ХХК Гэрээний үнийн дүн:14,988,600 төгрөг	100
74	Ерөнхий боловсролын сургуулиудад сурагчын ширээ, сандал худалдан авах	ХХО	Ширээ сандалын тоо Хөрөнгийн хэмжээ		100	Ерөнхий боловсролын сургуулиудад сурагчдын ширээ сандал худалдан авах гэрээг орон нутгийн байгууллага “Жанжин Чойр Бөхбат Хийц” ХХК-тай 20,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шууд худалдан авах гэрээ 2023 оны 03 сарын 27-ний өдөр байгуулж ерөнхий боловсролын 1, 2, 5-р сургуулиудад мэдээлэл зүйн кабинетын тус бүр 32 сурагчийн ширээ сандлыг хийлгэж 2023 оны 06 сарын 07-ний өдөр комисс ажиллаж ашиглалтад хүлээлгэн өгсөн.	100
75	2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв /ТЭЗҮ/ боловсруулах ажил	ХХО	Хэрэгжилтийн хувь		100	2023 оны Хөрөнгө оруулалтын ажлуудын төсөв боловсруулах гэрээг Монгол улсын мэргэшсэн төсөвчин Т.Ариунаатай байгуулж 2 ажлын 6 төсвийг 2023 оны 05 сарын 19-ний өдөр хүлээн авсан. Гэрээний үнийн дүн:2,800,000 төгрөг	100

Зорилт 13. Газрын харилцаа, хот байгуулалтын салбарыг орон нутагт хөгжүүлэх

76	Газрын биржийн цахим системийг ашиглан газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	1	Тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 10 нэгж талбарт газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн гэрчилгээний цахим дуудлага худалдааг сумын Засаг даргын 2023 оны А/51, 52 дугаар захирамжаар зарлаж, газрын цахим бирж (www.mle.mn) сайтанд байршуулж, ажилласан.	100
77	Хаягийн мэдээллийн нэгдсэн системд	ОНХС	Мэдээллийн сангийн гүйцэтгэлийн хувь	55.2	60	Хаягийн мэдээллийн цахим системд 7796 нэгж талбарын хаягийн засварлах ажлыг бүрэн хийж, мэдээллийн сангийн баяжилтыг өөрчлөлт орж	100

	мэдээллийг бүрэн оруулж, тогтмол шинэчилнэ.					байгаа бүрд баяжилтыг хийн ажиллаж байна. Нэр, хаяг олгогдоогүй шинээр бий болсон 3 авто замд нэршил өгөх асуудлыг, сумын орон тооны бус зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хэлэлцүүлж, баталгаажуулсан гудамж, зам болон нэрэмжит болгосон талбайг мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.	
78	Аялал жуулчлалын зориулалтаар олгосон газрын ашиглалтын гэрээг дүгнэж ажиллах		Хэрэгжилтийн хувь	-	100	Аялал жуулчлалын зориулалтаар эзэмшүүлсэн 2 нэгж талбарын 20000м2 газрын газар эзэмшүүлэх гэрээг дүгнэж, үнэлгээг өгч ажилласан. Гэрээний үнэлгээнээс Жанжин Чойрын Данжин сахиус ХХК хэвийн үйл ажиллагаа явуулж байгаа, Цайны зам фючер ХХК нь үйл ажиллагаа явуулаагүй тул газар эзэмших эрхийг дуусгавар болгох албан мэдэгдэл хүргүүлсэн.	90
Зорилт 14. Орон нутгийн батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилнэ							
79	Батлан хамгаалахын хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх	БТ	Хуулийн хэрэгжилтийн хувь Дайчилгааны төлөвлөлтийг шинэчилсэн эсэх	100 Тийм	- Дайчилгааны төлөвлөлтийг шинэчилсэн байна	Цэрэг татлага зохион байгуулахтай холбоотойгоор багийн Засаг дарга нар болон нийгмийн ажилтан нарт аймгийн цэргийн штабаас Батлан хамгаалах хуулиар мэдээлэл өгч, арга зүйгээр хангасан. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний хавсралт мэргэжлийн сумангийн удирдлагын томилгоог тодотгож аймгийн цэргийн штабт хүргүүлсэн.	100
80	Цэргийн бүртгэл, цэрэг татлагыг зохион байгуулах, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдэд сургалт, уулзалт зохион байгуулна.	БТ	Цэргийн бүртгэлийн хувь Цэрэг татлагын хамрагдалтын хувь Зохион байгуулсан сургалтын тоо	72.6 хувь 69.6 хувь 1	80% 80% 2	Сумын Засаг даргын 2023 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн А/01 дугаар захирамжаар цэргийн тоо бүртгэлийн 2023 оны 1 дүгээр сарын 09-ний өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 31-нийг өдрийг дуустал хугацаанд зарлаж явууллаа. Цэргийн тоо бүртгэлийн зарыг олон нийтийн цахим сүлжээ Сүмбэрийн мэдээ, choir zar medee, Sumder.gs.gov.mn цахим хуудаст зар мэдээллийг тогтмол оруулж олон нийтэд зарласан. Сумын хэмжээнд 2023 оны цэргийн тоо бүртгэлд нийт 3080 иргэн хамрагдахаас биеэр 2130, e-mongolia цахим системээр 459, нийт 2589 иргэн бүртгүүлж 84,1 хувийн биелэлттэй, хамрагдаагүй 491 иргэн байна. 2023 оны цэргийн тоо бүртгэлийн мэдээг	80

						өмнөх онтой харьцуулахад биеэр бүртгүүлсэн иргэд 16%, цахимаар бүртгүүлсэн иргэд 1,2 хувиар өсөж, бүртгэлд хамрагдаагүй иргэд 58,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	
81	Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	БТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Цэргийн насны залуучуудыг эрүүлжүүлэх арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	1 31	1 15	Цэргийн төв эмнэлэг, АЗДТГ-ын Цэргийн штаб, аймгийн Нэгдсэн эмнэлэг хамтран цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцэхгүй иргэдэд эрүүл мэндийн үзлэг хийж, Сүмбэр сумын хэмжээнд тайван цагт хугацаат цэргийн албанд эрүүл мэндээр тэнцэхгүй 25 иргэнийг Цэргийн эмнэлгийн комиссын үзлэгт хамруулж 12 иргэдийг газар дээр нь цэргийн албанд татахаас чөлөөлөх ажлыг зохион байгуулж ажиллалаа. Мөн ӨЭМТ-тэй хамтран хөдөөгийн багийн 18-25 насны 10 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.	100
82	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах, тэдний ар гэрт нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх.	БТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо Дэмжлэгт хамрагдсан иргэдийн тоо	- -	1 5	Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд цэргийн штабын дарга хурандаа Ц.Нацагдоржоор ахлуулсан ажлын хэсэг эцэг, эхчүүдийн хамт Зэвсэгт хүчний 016, 015, 0311 дугаар нэгтгэлд хугацаат цэргийн алба хааж буй цэрэг дайчидтай уулзалт хийсэн.	100
Хэсгийн дундаж үнэлгээ /14 зорилт 82 заалт/							
ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН БУЮУ НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт-1: Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын эрх, үүргийн хүрээнд аймаг, орон нутгийн бодлогыг төлөвлөн, төрийн байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах							
1	Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийг боловсруулах, жилийн ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж тайлагнах	БТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80%	80%	Төрийн албан хаагчийн сургалтын жилийн төлөвлөгөөг гарган батлуулж төлөвлөгөөний дагуу албан хаагчдын ур чадвар, чадавхыг дээшлүүлэх зорилгоор сургалтын нэгдсэн төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 252 албан хаагч хамрагдсан. Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд шатны багц сургалтад 1 албан хаагч, анхан шатны сургалтад 1 албан хаагч, АЗ сургалтад нийт 4 албан хаагч хамрагдаж тэнцсэн. Байгууллагын	70

						нийт албан хаагчдыг монгол бичгийн сургалтад хамруулж 8 албан сертификат авсан.	
2	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийг баталгааг хангах хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, жилийн ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангаж тайлагнах	БТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80%	80%	Байгууллагын албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Албан хаагчдын ур чадвар, чадавхыг дээшлүүлэх зорилгоор сургалтын нэгдсэн төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 252 албан хаагч хамрагдсан. Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд шатны багц сургалтад 1 албан хаагч хамрагдаж байна. Сумын Засаг даргын Тамгын газарт төрийн захиргааны 6 албан тушаалын сул орон тооны захиалгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж 3 сул орон тоо нөхөгдсөн. ТЖАХ-ийн ерөнхий шалгалтад түр томилгоотой 2 албан хаагч шалгалт өгч тэнцсэн. Байгууллагын нийт албан хаагчдыг монгол бичгийн сургалтад хамруулж 8 албан сертификат авсан.	90
3	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1991 оны 115 дугаар зарлиг, Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны А/215 дугаар захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд Угийн бичиг хөтлөх анхан шатны сургалтанд албан хаагчдаа хамруулж угийн бичиг хөтлүүлэх		Угийн бичгийн сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо Хамрагдалтын хувь Угийн бичиг хөтөлж байгаа албан хаагчдын тоо	25 100 2	32 100 6		50
4	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эрт илрүүлгийн үзлэг оношлогоонд хамт олныг хамруулах, идэвхитэй		Хамрагдсан албан хаагчдын тоо Хамрагдалтын хувь	22 72,6	- -	Байгууллагын ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд эрт илрүүлгийн үзлэг оношлогоонд 2022 онд 16 албан хаагч хамрагдсан. 2023 оны 3-р улиралд ажилчдыг эрт илрүүлгийн үзлэг	30

	оролцоог хангаж хамтран ажиллах.					оношлогоонд бүрэн хамруулахаар төлөвлөөд байна.	
5	Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулж, гарсан шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулж, тайлагнах	-	УАШЗөвлөгөөний тоо ЗДЗХурлын тоо ХШҮ хийсэн тайлангийн тоо Үүргийн гүйцэтгэлийн хувь	26 13 24 94.2 хувь	26 6 24 100 хувь	Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд 8 удаа өөрсдийн хийж гүйцэтгэсэн ажлын мэдээллийг бэлтгэн байгууллагын дарга тогтмол оролцон 7 удаагийн 38 үүрэг даалгварыг тухай бүр биелүүлэн, үүргийн биелэлт 95 хувьтай байна.	100
6	Сумын Засаг даргын Тамгын газарт төрийн үйлчилгээг сайжруулах зорилгоор Чанарын удирдлагын тогтолцоо ISO стандартыг нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах	-	Хэрэгжилтийн хувь ISO стандарт нэвтрүүлсэн сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	30 хувь 1	100 хувь 4	Сүмбэр сумын ЗДТГазрын үйл ажиллагаанд ЧМТ-ны стандарт нэвтрүүлэхээр гэрээ байгуулан гэрээний дагуу стандартын шаардлагын дагуу сургалт болон зөвлөх үйлчилгээг үе шаттай хамтран зохион байгуулж стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний хүрээнд зөрүүгийн шинжилгээг баримт бичигтэй танилцах, албан хаагч нартай ярилцлага хийх, ажлын орчны ажиглалт хийх аргачлалаар хийж гүйцэтгэн тайланг боловсруулж танилцуулахаас гадна Чанарын удирдлагын багийн гишүүдийг 2 удаа Улаанбаатар хотод вакумжуулсан сургалтаар 8 ажилтанг хамруулан чадавхижуулсан. ISO стандартын шаардлагын дагуу хийсэн зөрүүгийн шинжилгээний зөрүүг арилган энэ онд багтаан дуусгахаар гэрээг шинэчлэн байгуулсан.	70
7	Сумын харьяа байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг үнэлэх	-	ХШҮ хийсэн байгууллагын тоо Өгсөн зөвлөмжийн тоо	5 0	3 3	Сумын хэмжээнд үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу эхний хагас жилийн байдлаар 3 сургууль, 4 цэцэрлэгийн үйл ажиллагааны сургалтын чанар, үдийн хоолны чанарт нийт 2 удаагийн хяналт шалгалт хийж зөвлөн тусалж, арга зүйгээр хангаж ажилласан. Захирал эрхлэгч нарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан, хэрэгжилтийн хагас жилийн гүйцэтгэлд үнэлгээ хийгдэж байна.	90

8	Сумын харьяа байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх, эрсдлийн удирдлагаар хангах	-	Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо Өгсөн зөвлөмжийн тоо	-	7 - 7	9-р сард зохион байгуулахаар төлөвлөгдсөн	-
9	Сумын Засаг даргаас шагнал олгох арга хэмжээг зохион байгуулах	-	Журмын хэрэгжилтийг хангасан байдал	Журмын дагуу 36 иргэн, 3 байгууллагад шагнал олгосон.	Журмын дагуу шагналыг олгосон байна.	Сүмбэр сумын баг, байгууллагаас төрийн 29, сумын Засаг даргын 25, алдарт эхийн 1,2 дугаар одонгийн 65, нийт 119 иргэний шагналд тодорхойлогдож ирсэн материалыг хүлээн авч, журмын дагуу бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газарт уламжлан хүргүүлсэн.	100
10	Сумын Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн системийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хувийн хэргийн бүрдлийг хангуулах, баяжилт хийх	-	Хугацаанд нь тайлагнасан эсэх Үнэн зөв тайлагнасан байдал	Тийм Үнэн зөв тайлагнасан байдал	Тийм Үнэн зөв тайлагнасан байдал	ХНУТ-ын шинэчлэлтэй холбоотой 32 албан хаагчийн мэдээлэл болон шинээр томилогдсон болон гарсан албан хаагчдыг тухай бүр хугацаанд нь оруулсан эсэхэд, тогтмол хяналт тавин ажиллаж байгаа ба нийт албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг бүрэн хангуулж ажилласан.	100
11	Сумын Засаг даргын Тамгын газрын дотоод үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр ханган, үр дүнг тайлагнах. - Сумын Засаг даргын Тамгын газрын дотоод журмыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангуулан, үр дүнг тайлагнах - Сумын цаг үеийн мэдээг сар бүр нэгтгэн гаргаж аймгийн ТЗУХ-т хүргүүлэх - Сумын Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг	БТ	Дотоод журмыг шинэчлэн боловсруулж мөрдөж байгаа байдал Хэрэгжилтийн хувь Шийдвэрлэлтийн хувь	Тийм 100 хувь	Тийм 100 хувь	Сумын ЗДТГ-ын хийж гүйцэтгэсэн сарын ажлын мэдээг сар бүрийн 25-ны дотор өдөр 5 удаа гарган аймгийн ТЗУХ-т хүргүүлсэн. 2023 оны 05 сарын 10-ны өдрийн байдлаар Сумын Засаг дарга түүний Тамгын газарт нийт- 69 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирсэн. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас сумын Засаг дарга түүний Тамгын газарт хандаж ирүүлсэн өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг тухай бүр өгч ажиллалаа. Ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл: • Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, хүүхэд үрчлэх, тухай-10 • Хандив, буцалтгүй тусламж, тоног төхөөрөмж хүссэн-4 • Тусгай зөвшөөрөл /тамхи, бильярд, тоглоомын газар/ - 4 • Худаг усны асуудлаар- 2 • Газрын асуудлаар- 41 • Хог хаягдалаар – 3	100

	<p>боловсруулан, хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнах</p> <p>- Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, хугацаанд нь шийдвэрлүүлж, нутгийн захиргааны байгууллагуудын өргөдөл, гомдлын тайланг нэгтгэн ТЗУХ-т хүргүүлэх.</p> <p>- Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зааврын дагуу зохион бүрдүүлэх</p> <p>- Байгууллагын архивыг нөхөн бүрдүүлэх, цахимжуулах</p> <p>- Сумын Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаалын хэрэгжилтийг хангуулж, үр дүнг нэгтгэн тайлагнах</p>		<p>Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь</p> <p>Байгууллагын архивын цахимжуулалтын хувь</p> <p>Захирамж, тушаалын хэрэгжилтийн хувь</p>	<p>98.0</p> <p>100 хувь</p> <p>60 хувь</p> <p>98.0 хувь</p>	<p>100</p> <p>70 хувь</p> <p>70 хувь</p> <p>70 хувь</p>	<p>• Бусад-6</p> <p>Нийт 69 өргөдлөөс 59 бүрэн шийдвэрлэж 85%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу цахим болон цаасан хэлбэрээр албан бичгийг бүртгэн, хөтлөх нэрийн жагсаалтын дагуу 62 баримт авахаас 32 баримт хүлээн аваад байна. Сар бүр архив, албан хэрэг хөтлөлтийн тайлан мэдээг гарган нэгжийн удирдлагад танилцуулж хэвшсэн ба монгол бичгийг албан хэрэг хөтлөлтөд нэвтрүүлэх ажлын хүрээнд албан бланкуудыг монгол бичигт хөрвүүлэн бэлтгэн эх бэлтгэн 04.10-ны өдрөөс эхлэн монгол бичгийг албан хэрэгцээнд нэвтрүүлсэн.</p>	
12	<p>Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж мөрдүүлэх</p>	-	<p>- Бүртгүүлсэн захиргааны хэм хэмжээний актын биелэлтийн хувь</p>	100 хувь	70 хувь	<p>Сумын Засаг даргын Тамгын газарт захиргааны хэм хэмжээ тогтоосон 3 актыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай 2020.12.17 №11” УМСанд 2021.01.11 №4963 бүртгэгдсэн. 2. “Бэлчээр ашиглалтын журам 2021.12.20 №06” УМСанд 2022.01.07 №5664 бүртгэгдсэн 3. “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоох тухай 2023.07.05 №04” УМСанд 2023.07.31 №6236 бүртгэгдсэн. 	100

13	Сумын Засаг даргын Тамгын газарт дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах үйл ажиллагааг тогтмолжуулах.		Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	0	100 хувь	Сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/ тоот тушаалаар байгууллагын дотоод хяналтын баг томилсон. 2023 онд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж батлуулсан. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан гүйцэтгэлд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр ажиллаж илэрсэн зөрчлийг арилгаж дахин давтан гаргахгүй байхад анхаарч явцын хяналт шалгалтыг тогтмолжуулан ажиллаж байна.	70
14	Байгууллагын гадна талбайг тохижуулж, гэрэлтүүлэг, хаягжилт, камержуулалт, ногоон байгууламжийг сайжруулах.		Гэрэлтүүлсэн талбай Камержуулсан байдал Ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байдал Гадна талбайн тохижилтыг сайжруулсан байдал	Камертай -	Ногоон байгууламж нэмэгдүүлсэн байх	Байгууллагын гадна талын фасадны ажлыг эхлүүлсэн. Ногоон байгууламжийн хүрээнд 15 ширхэг голт бор 10 ширхэг монос нийт 25 мод шинээр тарьсан мөн 4 төрлийн цэцэг тарьсан. Байгууллагын аюулгүй байдлыг хангах хүрээнд 1 камер суурилуулсан. Цаашид гадна талд 3 камер нэмэгдүүлэх шаардлагатай. 2024 оны төсөвт тусгасан.	100
15	Байгууллагын ажилтнуудыг худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамруулж АЗ гэрчилгээтэй болгох		Шинээр АЗ гэрчилгээ авсан албан хаагчдын тоо	3	3	2023 онд худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад 4 албан хаагчийг хамрагдаж 100 хувь амжилттай суралцаж тэнцсэн. Сургалтын зардалд 340.000 төгрөгийг зарцуулсан.	100
16	Албан хаагчдын эрх зүйн боловсролд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.		Зохион байгуулсан эрх зүйн сургалтын тоо, Хамрагдсан албан хаагчдын тоо	12 22	22 32	Байгууллагын албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Албан хаагчдын ур чадвар, чадавхыг дээшлүүлэх зорилгоор сургалтын нэгдсэн төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 252 албан хаагч хамрагдсан. Удирдлагын академийн мэргэшүүлэх дунд шатны багц сургалтад 1 албан хаагч, анхан шатны сургалтад 1 албан хаагч, АЗ сургалтад нийт 4 албан хаагч хамрагдаж тэнцсэн. Байгууллагын нийт албан хаагчдыг монгол бичгийн сургалтад хамруулж 8 албан сертификат авсан.	90

17	Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд олон нийтийг хамарсан нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажиллах		Хамтран ажилласан арга хэмжээний тоо Үүрэг даалгаврын биелэлт	Шинэ ажил	- 1	Монгол Улсын Ерөнхий сайдын Л.Оюун-эрдэнийн санаачилган доор зохион байгуулагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт, онцлох ажлууд”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийн явцын талаарх зөвлөлдөх уулзалт 6 дугаар сарын 9,10-нд зохион байгуулагдсан форум уулзалтад нийт 8 албан хаагчийн хамрагдсан. Мөн аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Алсын хараа 2050” сургалтад 5 албан хаагчийн хамруулсан. 6-р сард зохион байгуулагдсан багийн иргэдийн нийтийн хурлын үеэр шинэ сэргэлтийн бодлогыг талаар 543 иргэдэд мэдээлэл хүргэж тайлан мэдээг ЗГХЭГ-т хүргүүлсэн.	100
18	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг иргэдэд сурталчлах, мэдээллэх, иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулахад хамтран ажиллах	-	Зохион байгуулсан уулзалтын тоо	3	2	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтийн тайлант нэвтрүүлгийг Сүмбэр мэдээ болон аймгийн Засаг даргын Тамгын газрын пэйж хуудсаар олон нийтэд мэдээлсэн. Мөн байгууллагын цахим хуудаст байршуулсан. 2023 оны хагас жилийн гүйцэтгэлийг гаргаж сумын ИТХ-д тайлагнасан. Сүмбэр мэдээ фейсбүүкээр өдөр тутам мэдээлэл бэлтгэн тавьж иргэдэд үйл ажиллагааг сурталчилж байна.	70
19	Байгууллагууд албан ёсны цахим хуудсанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан нээлттэй мэдээллийг байршуулах, олон нийтэд ил тод мэдээлэх.	БТ	Хуулийн хэрэгжилт, хувь	100 хувь	- 100 хувь	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан нээлттэй мэдээллийг байршуулах хүрээнд байгууллагын http://sumber.qs.gov.mn цахим хуудаст үндсэн 8 цэс, дэд 24 цэст 123 мэдээ оруулж байршуулсан байна.	90
20	Байгууллагын гүйцэтгэлийн үр дүнг сайжруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх.		Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	89 хувь 100 хувь	95-аас дээш хувь - 100 хувь	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх, гүйцэтгэл сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж баталсан. төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг 98,6 хувийн биелэлттэй хангаж аймгийн ХШҮХ-т тайлан мэдээг хүргүүлсэн.	90

			- ХШҮ-ний зөвлөмжийн хэрэгжилт /хувь/				
21	Байгууллагын дэргэдэх зөвлөлүүдийн шинэчлэн байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах		- Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь	85	- 90-ээс доошгүй	Байгууллагын дэргэд ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2019 оны "Эцэг эхийн зөвлөл байгуулах журам", Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргын 2023.02.14 А/14 тоот захирамжаар байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-ийг шинэчлэн байгуулсан. Эцэг эхийн зөвлөл жилийн ажлын төлөвлөгөө гаргаж 3 удаагийн арга хэмжээ зохион байгуулж байгууллагын албан хаагч, хүүхдийг хамруулсан.	70
22	Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, ахмадуудад чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээ зохион байгуулах.		Ахмадын санд төвлөрүүлсэн төсөв Зохион байгуулсан арга хэмжээний тоо Зарцуулсан зардал / мян.төг/	10000,0 сая 2 4250,0	1 5840,0	Байгууллагын харьяанд нийт 26 ахмад настан байдаг. 2023 оны сар шинийн баяраар 5840,0 мянган төгрөг зарцуулж хүндэтгэл үзүүлсэн.	100
Зорилт 2. Хүний эрх, хууль ёс, шударга байдлыг бэхжүүлж иргэдийн аюулгүй амар тайван байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх							
23	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бодитой ажил төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллах		Төлөвлөгөөний хэрэгжилийн хувь Авлига, ашиг сонирхлын зөрчил гараагүй байх	100 Авлига, ашиг сонирхлын зөрчил гараагүй	100 Авлига ашиг сонирхлын зөрчил гараагүй байна.	Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний хүрээнд АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэрэг 6 төрлийн мэдээ мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фейсбүүк/-д байршуулан иргэдэд хүргэсэн. Монгол Улсын Засгийн газраас "Авлигатай тэмцэх таван ажиллагаа"-ний нэг арга хэмжээ болох "ШҮГЭЛ АЖИЛЛАГАА"-г зарласантай холбогдуулан авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан "НЭГДЬЕ", "ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЭЭД	90

						ӨӨРЧИЛЬЕ” аяныг иргэдэд байгууллагад веб сайт, фейсбүүк хаягаар сурталчилсан. Дээрх аянд байгууллагын 28 албан хаагч нэгдсэн. Төрийн захиргааны 23 албан хаагчдын ХАСХОМ-ийг хүлээн авч баталгаажуулан хугацаанд нь тайлагнасан. Мөн 7 албан хаагчийн ХАСУМ хянуулж цахим хуудаст байршуулсан.		
24	Байгууллагын албан хаагчдыг архи, согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, албан байгууллага дотор болон бусад хэлбэрээр архидан согтуурах явдлыг таслан зогсоох.		Байгууллагад зохион байгуулсан арга хэмжээний тоо Албан хаагчид архи согтууруулах ундаанаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчилд өртөөгүй байх	2	Зөрчил гараагүй	1 Зөрчил гараагүй байна.	Байгууллагын албан хаагчдыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд жилийн ажлын төлөвлөгөөг 5 арга хэмжээтэй төлөвлөж батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран байгууллагын албан хаагчдад шинэчлэн батлагдсан “Согтууруулах ундааны эрэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-иар 1 удаагийн сургалт зохион байгуулж 24 албан хаагчийг хамруулсан. Гэмт хэргийн шинжтэй зөрчил гараагүй.	70
25	“Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх	ОНХС 2,0	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	100 хувь		70 хувь	“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-н хүрээнд байгууллагын эрх зүйн хөтөч ажиллах төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна. 2023 онд эрх зүйн хөтөчийн сургалтад 1 албан хаагч хамрагдсан. Төлөвлөгөөний хүрээнд 3 удаагийн сургалт зохион байгуулж 76 иргэнийг хамруулсан. Мөн www.e-khutuch.mn эрх зүйн цахим хөтчөөр дамжуулан 35 иргэнд мэдээлэл хүргэн ажилласан.	90
26	Сумын хэмжээнд Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх, команд штабын сургалт зохион байгуулах	ОНХС 16,550	Сумын хэмжээнд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн тоо Зохион байгуулсан сургалтын тоо	- 100 хувь		1 100 хувь	Мэргэжлийн албадыг сургаж дадлагажуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор Гамшгаас хамгаалах команд штабын сургалтыг 04 сарын 05-ний өдөр зохион байгуулан 1,722,450 төгрөг зарцуулсан. Мөн улсын хэмжээнд зохион байгуулагдсан газар хөдлөлтийн стратегийн команд штабын сургуулилтад мэргэжлийн ангийн албан хаагчид бүрэн хамрагдсан. 2022 онд сумын мэргэжлийн тусгай ангийн албадын гишүүдийг хөдөлмөр хамгааллын хувцсаар хангасан.	100
Хэсгийн дундаж үнэлгээ /2 зорилт 27 арга хэмжээ/							84.3	

ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Зорилт 1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, иргэд, олон нийтэд мэдээ, мэдээлэл, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх орчин нөхцлийг бүрдүүлнэ.

1	e-mongolig систем, ХУР, ДАН систем, тоон гарын үсгийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, операторын системийг нэвтрүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх	-	E Mongolia системээр үйлчлүүлсэн иргэдийн тоо	856	500	Е-монголиа системийн брендбүүкээр ХУРДАН буланг шинээр байгууллагын 1 давхарт үүсгэж иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Эхний 6 сарын байдлаар 11 төрлийн 234 лавлагаа олгосон байна. 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сүмбэр сумын 6-р багийн нутаг дэвсгэр Малх толгойд үүрэн телефоны дахин дамжуулах станц байрлуулах ажлыг Unitel ХХК хийж гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд 30 км радиустайгаар барих бөгөөд 6-р багийн 243 өрх сүлжээнд бүрэн холбогдсон байна. Хөдөөгийн малчдад багийн өдөрлөг, уулзалтаар e-mongolia системийг ашиглаж хэрхэн лавлагаа мэдээлэл авах талаар нийт 150 малчинд арга зүйн зөвлөгөө өгсөн. Мөн E-mongolia системийг иргэдэд сурталчлах ажлын хүрээнд 210 иргэнд гарын авлага материал тарааж 51 иргэний гар утсанд апп татан өгч арга зүйгээр хангаж ажилласан.	90
2	Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах - сумын Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах - сумын мэдээллийн сонинг улирал тутамд хэвлүүлж, иргэдэд түгээх - сумын цахим хуудас, олон нийтийн сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, дэвшилтэт технолигийг ашиглах замаар мэдээ,	ОНХС 16,140	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Зохион байгуулсан уулзалтын тоо Хэвлүүлсэн сонингийн тоо Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн тоо	90 хувь 2 2000 132	100 хувь 4 4000 200	Сумын Засаг дарга болон ЗДТГ-ын ажлын талаарх цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүрд нь мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэж ажиллаж байна. Сүмбэрийн мэдээ фейсбүүк хуудсаар нийт 622 мэдээг нийтэлсэн ба байгууллагаас бэлтгэсэн мэдээлэл 287 , бусад байгууллагын 335 мэдээг шэйр хийж ажилласан байна. “Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт”-ийн дагуу байгууллагын цахим хуудаст одоогийн байлаар 4 цэсэнд 10 мэдээлэл шинэчлэн байршуулсан. Мөн Сүмбэрийн мэдээ фейсбүүк хуудсаар дамжуулан нийтлэсэн мэдээллүүд 06 сарын 20-ны байдлаар давхарлсан тоогоороо - 10800 хандалт авсан. Тус хандалтын 50%-ийг лайк, 35%-ийг шэйр, 15%-ийг коммент эзэлж байна. Сүмбэрийн мэдээгээр дамжуулан өдөр бүр малчид, иргэдэд цаг агаарын мэдээллийг тогтмол хүргэдэг.	70

	мэдээллийг иргэдэд ил тод хүргэх - Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, цахим болон теле контент, шторкийг бэлтгэн иргэдэд хүргэх						
3	Сумын Засаг даргын Тамгын газар болон нутгийн захиргааны байгууллагуудад дотоод удирдлагын цахим ERP системийг төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудад бүрэн нэвтрүүлж, төрийн цахим шуудан, Үндэсний дата төвтэй хамтран төрийн байгууллагын домайн нэртэй болгох	-	ERP системийн ашиглалтын хувь	- 17	70 20	Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн "ERP" системийг бүрэн нэвтрүүлсэн. "ERP" системийн албан бичиг хэргийн дэд системээр дамжуулан байгууллагад 220 албан бичиг ирсэн үүнээс шийдвэрлэсэн 105, судлагдаж байгаа 35, эргэн танилцах 3, хугацаа дөхсөн 1, хугацаа хэтэрсэн 2, буцаасан 2 албан бичиг байна. Байгууллага хооронд албан бичгийн хариуг ERP болон цаасаар хүргүүлж байна. Нийт 26 албан хаагч Егр системийг ашиглаж байна. Албан хаагчдын ашиглалт 70 хувьтай.	70
4	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх.	-	Цахимаар шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо, шийдвэрлэлтийн хувь	5 100%	Ирсэн тоогоор - 100%	Тамхины тусгай зөвшөөрөл хүссэн 3 иргэний баримтыг цахимаар хүлээн авч холбогдох мэргэжилтэнд өгч хугацаанд нь шийдвэрлэн өгсөн. Тус зөвшөөрөл нь сумын ЗД-ын А/10, А/27, А/32 дугаартай Захирамжаар шийдвэрлэсэн.	100
5	Цаг үеийн мэдээ, мэдээллийг олон нийтэд түргэн шуурхай хүргэх, нийтэд ил тод байх, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага болон АЗДТГазрын хэвлэл, мэдээллийн багтай хамтарч ажиллах	БТ	Хэвлэл мэдээллийн багийн группт оруулсан мэдээний тоо Хамтран ажилласан хэвлэл мэдээллийн байгууллагын тоо	4 2	20 мэдээ	Байгууллагын сайт болон фейсбүүк хуудсаар сум, багийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын ажлын талаарх мэдээллийг цаг бүр, тухай бүрд нь мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэн ажиллаж байгаа ба мөн сар бүрийн хийсэн ажлын тайланг видео хэлбэрээр түгээж байна. Сүмбэрийн мэдээ фейсбүүк хуудсанд Нийт 622 мэдээлэл /өөрсдийн бэлтгэсэн 287, бусад байгууллагын 335 мэдээлэл/ байршуулж давхардсан тоогоор 10800 хүний хандалт авсан байна.	100
Хэсгийн дундаж үнэлгээ /1 зорилт 5 арга хэмжээ/							85,4

2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

№	Үндсэн чиг үүрэг	Зорилт	Арга хэмжээний тоо	Дундаж үнэлгээ
1.	Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	14	82	85,5
2	Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх	2	27	84,3
3.	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ	1	5	85,4
	Дундаж үнэлгээ	17	114	85.06

СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР